



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/07

Даланзадгад

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дүгээр зүйлийн 12.1 дэх заалтын 12.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн салбарын шилдэг шалгаруулах журмыг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагад дэмжин туслах үйл ажиллагааг зохион байгуулах дарга, мэргэжилтэн нарын жагсаалтыг хоёрдугаар, дэмжин туслах үйл ажиллагааны журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (М.Цэндсүрэн), эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга (Ж.Отгонбайгал), нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга (Б.Амгалан) нарт даалгасугай.
3. Журмыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий сум, өрх, зоонозын өвчин судлалын төв, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, дарга нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Б.Мидэрсүрэн)-д даалгасугай.
5. Цаашид эрүүл мэндийн байгууллагуудад дэмжин туслах үйлчилгээний талаар бодлого барьж ажиллахыг эрүүл мэндийн газрын хэлтсийн дарга, мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ШИЖИРТУЯА



My computer 2021 tushaal

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
02 дугаар сарын 18-ны өдрийн
А/07 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Эрүүл мэндийн салбарын шилдэг шалгаруулах, шагнаж урамшуулах, сурталчлах, тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Шалгарсан ажилтан, хуулийн этгээдэд тухайн оны өргөмжлөлийг Эрүүл Мэндийн Газрын даргын шийдвэрээр олгоно.
- 1.3. Энэхүү үйл ажиллагааг аймгийн хэмжээнд жил бүр тогтмол зохион байгуулж, явуулна.

ХОЁР. НЭР ТОМЬЁО

- 2.1. “шилдэг эрүүл мэндийн ажилтан” гэж тухайн оны шилдэг эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг;
- 2.2. “шилдэг сувилагч” гэж тухайн оны шилдэг сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг үзүүлэгч буюу өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах ажилтныг;
- 2.3. “шилдэг эмч” гэж тухайн оны шилдэг эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг үзүүлэгч буюу өвчнийг оношлох, эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажилтныг;
- 2.4. “шилдэг эрүүл мэндийн байгууллага” гэж тухайн оны шилдэг хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;
- 2.5. “дэмжин туслах үйл ажиллагаа” гэж эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн холбогдох хууль, тогтоомж, заавал мөрдөх стандарт, дүрэм, журам, удирдамж, зааврыг биелүүлж байгаа эсэхэд дэмжин туслах цогц арга хэмжээг хэлнэ
- 2.6. “дэмжин туслах баг” гэж эрүүл мэндийн газрын дэргэд байгуулагдаж, багийн дарга, нарийн бичиг, гишүүд бүхий дэмжин туслах үйл ажиллагаа явуулах дэд комиссыг хэлнэ.

ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ БА УРАМШУУЛАЛ

- 3.1. Шалгаруулах үйл ажиллагаа нь хоёр үе шаттай явагдах бөгөөд эхний шатыг дэд комисс, хоёр дахь шатыг эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр дүгнэнэ.
- 3.2. Эхний шатны шалгаруулалт:
 - 3.2.1. Эхний шатны шалгаруулалтыг дэд комисс байгуулж, шалгаруулна.
 - 3.2.2. Шалгаруулалтад оролцож байгаа байгууллага нь дэд комисст хүсэлтээ албан бичгээр холбогдох материалын хамт жил бүрийн 11 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлсэн байна.
 - 3.2.3. Дэд комисс нь ирүүлсэн материалд дүгнэлт гаргаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл цуглуулж, жил бүрийн 11 дугаар сарын 15-ны дотор эрүүл мэндийн газрын даргад санал хүргэнэ.
- 3.3. Хоёр дахь шатны шалгаруулалт:
 - 3.3.1. Эрүүл мэндийн газрын дарга нь дэд комиссоос ирүүлсэн саналыг үндэслэн, хэлтсийн дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор дүгнэлт гаргаж, шилдгүүдийг шалгаруулна.
 - 3.3.2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар гэрчилгээг дагалдах мөнгөн шагналын хэмжээг тогтоож, шийдвэрлэн шагналыг гардуулна.

Эрүүл мэндийн газрын 2022 оны
02 дугаар сарын 18-ны өдрийн
A/07 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ДЭМЖИН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ДАРГА, МЭРГЭЖИЛТЭН НАРЫН ЖАГСААЛТ**

№	Эрүүл мэндийн байгууллага	Нэгж /төв, тасаг/	Хариуцсан ажилтан	Холбогдох утас
1.	Дотор, хөнгөвчлөх, арьс харшил, уламжлалт, мэдрэл, сэтгэц	Тасаг	Б.Мидэрсүрэн	86642980
2.	Мэс засал, гэмтэл	Тасаг	Б.Амгалан	88053387
3.	Хүүхэд, нярай	Тасаг	М.Цэндсүрэн	88095538
4.	Төрөх, эмэгтэйчүүд	Тасаг	Ж.Отгонбайгал	99003543
5.	Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, яаралтай түргэн тусламж	Тасаг	Б.Ганшагай	88636564
6.	Халдварт, сүрьеэ	Тасаг	Б.Бямбажав	88174755
7.	Зөвлөх поликлиник, дэмжих үйлчилгээ	Тасаг	Г.Амартүвшин	99944166
8.	Дүрс оношилгоо, нэгдсэн лаборатори	Тасаг	Б.Машбаяр	99057764
9.	Зоонозын өвчин судлал	ЗӨСТөв	Б.Булганчимэг	88101027
10.	Баяндалай	СЭМТөв	Ц.Мандах	88063658
11.	Баян-овоо	СЭМТөв	Д.Оюунцэцэг	88537070
12.	Булган	СЭМТөв	М.Нямдулам	88056008
13.	Гурвантэс	СЭМТөв	Б.Ган-эрдэнэ	90749444
14.	Мандал-овоо	СЭМТөв	А.Мөнхтуяа	88537136
15.	Манлай	СЭМТөв	Б.Мөнхгэрэл	89046489
16.	Номгон	СЭМТөв	Д.Гантогтох	86565685
17.	Ноён	СЭМТөв	Б.Буянарвижих	88895005
18.	Сэврэй	СЭМТөв	Б.Мөнхжин	88701524
19.	Ханбогд	СЭМТөв	Т.Оюунтуул	89036616
20.	Ханхонгор	СЭМТөв	Б.Мэндбаяр	88190585
21.	Хүрмэн	СЭМТөв	Н.Уранчимэг	89009438
22.	Цогт-овоо	СЭМТөв	Э.Ууганцэцэг	88559054
23.	Цогт-цэций	СЭМТөв	Ө.Ууган-өлзий	88132949
24.	Өнө-орших	ӨЭМТөв	Д.Сэлэнгэ	99729745
25.	Шимбилэг	ӨЭМТөв	М.Цэцэгсүрэн	88447075
26.	Энхийн хүслэн	ӨЭМТөв	О.Номин-эрдэнэ	89447900



ДЭМЖИН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО.

- 1.1. Шилдэг болох зорилт тавин ажиллаж байгаа ажилтан, хуулийн этгээдэд бодитой үнэлгээ өгч, дэмжин туслах байдлаар үйл ажиллагааг сайжруулах талаар хамтын ажиллагааг явуулах.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.

- 2.1. Дэмжин туслах ажлыг удирдан зохион байгуулахад эрүүл мэнд, хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан хууль, тогтоомж, тушаал, шийдвэр болон бусад холбогдох хууль эрхийн актыг мөрдлөг болгоно.
- 2.2. Эрүүл мэндийн байгууллага болон дэмжин туслах багийн гишүүд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн үндсэн тулгуур зарчмыг баримтлан, харилцан хүндэтгэлтэй хандаж, хамтран ажиллана.
- 2.3. Дэмжин туслах үйл ажиллагаа нь хариуцсан эрүүл мэндийн байгууллага, тасаг нэгжид тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн саналыг Эрүүл мэндийн газарт болон тухайн эрүүл мэндийн байгууллагад гаргана.
- 2.4. Дэмжин туслах эрүүл мэндийн байгууллагад газар дээр нь очиж, тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцаж, дүгнэлт хийх, зөвлөмж, чиглэл өгч мэргэжил арга зүйгээр хангаж болно.
- 2.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн санал, санаачилга, сургалтыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 2.6. Дэд комиссын ажлын хэсэг нь шалгаруулалтад ирсэн материалыг үнэлгээний шалгуурын дагуу үнэлэхээс гадна, хяналт үнэлгээг зохион байгуулж, үр дүнг хурлаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 2.7. Дэд комисс нь гишүүдийн 50 хувиас дээш оролцсон тохиолдолд хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 2.8. Дэд комиссын нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэл хөтөлж, хурлын дарга, гишүүд гарын үсэг зурснаар шийдвэр баталгаажна.
- 2.9. Шалгаруулалтад тэнцсэн байгууллагыг газар дээр нь очиж танилцан баталгаажуулна.